



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.04.01 № 01/527

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус компаниас зарласан ЭТТХК/20240101101 дугаартай Далд уурхайн хайгуулын өрөмдлөг хийх гүйцэтгэгчийг сонгох тендертэй холбоотой тендерт оролцохыг сонирхогч этгээдээс тодруулга ирүүлснийг хянан үзээд дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Ажлын даалгаврын 4.1-д заасан шаардлага ТШЗ 19.2 -ын 4.1-д заасантай утга давхцаж буй учир хасах;

2. Тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д заасан “Борлуулалтын орлогын хэмжээ: 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлого нь багц тус бүрийн батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувь болон түүнээс багагүй байна.” гэснийг Борлуулалтын орлогын хэмжээ: 2021, 2022, 2023 онуудын борлуулалтын орлогын нийлбэр нь багц тус бүрийн батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувь болон түүнээс багагүй байна гэж өөрчлөх;

3. Тендерийн баримт бичгийн ТШЗ 18.1-д заасан “Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Багц тус бүрийн батлагдсан төсөвт өргийн 30 хувиас багагүй байна.” гэснийг Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Багц тус бүрийн батлагдсан төсөвт өргийн 20 хувиас багагүй байна. гэж өөрчлөх;

4. Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д “Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага: 2021, 2022, 2023 онуудын аль нэг жилд хийж гүйцэтгэсэн нийт ажлын гэрээний үнийн дүнгийн нийлбэр багц тус бүрийн батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

- Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар
- Гэрээ дүгнэсэн акт эсхүл бүрэн хийж гүйцэтгэж дууссан ажлын захиалагчийн тодорхойлолт ирүүлэх /Ижил төстэй ажилд хайгуулын өрөмдлөг гүйцэтгэсэн туршлагыг тооцно./” гэснийг Ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн туршлага: Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудад 2-оос доошгүй ижил төстэй ажлын үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх.

- Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар
- Гэрээ дүгнэсэн акт эсхүл бүрэн хийж гүйцэтгэж дууссан ажлын захиалагчийн тодорхойлолт ирүүлэх /Ижил төстэй ажилд хайгуулын өрөмдлөг гүйцэтгэсэн туршлагыг тооцно/ гэж өөрчлөх;

5. Тендерийн баримт бичгийн Ажлын даалгаврын 7.1-д заасан шаардлага нь тендерт шалгарсан этгээдэд хамаарах тул өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-д заасан хүний нөөцийн мэдээллийг ТШЗ 19.2-т заасны дагуу ирүүлнэ.

1124040986

6. Тендерийн баримт бичгийн Ажлын даалгаврын 4.18-д заасан шаардлагын дагуу Гүйцэтгэгч тал бүрэн хариуцах ба гэрээний хэрэгжилтийн явцад “Цооног өрөмдөх, тоноглох, сэргээн засварлах гэрчилгээ”-тэй компаниар худгийн өрөмдлөгийн ажил гүйцэтгүүлнэ.

7. Тендерийн баримт бичгийн Ажлын даалгаврын 7-д заасан зөөврийн байрнуудыг ажлын даалгаврын 7.6-д заасны дагуу шалгарсан этгээдүүд хамтран шийдвэрлэнэ.

8. ТШЗ 18.2.2 -т заасан Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг нотлох баримтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/, болон Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/259 дугаар тушаалын хавсралт”-аар батлагдсан жишиг баримт бичигт үндэслэсэн болно.

Жич: Тендерт оролцохыг сонирхогч этгээдүүдээс ирүүлсэн тодруулгыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ -ийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан зарчимтай нийцүүлж, тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсан ба энэхүү нэмэлт өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох тул тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн бэлтгэхийг анхаарна уу.

ЗАСГИЙН ГАЗРЫН ОНЦГОЙ
БҮРЭН ЭРХТ ТӨЛӨӨЛӨЧ



Ж.ГАНБАТ